Үйл ажиллагааны орлогын	13821.7	18530.2	134.1	4708.5
Хөрөнгө борлуулсны орлогын	12076.7	7891.6	65.3	-4185.1
Орлогыг тодорхойлох боломжгүй иргэний	1719.4	1714.5	99.7	-4.9
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-20240.0	-20234.6	100.0	5.4
Бусад	17984.8	22700.2	126.2	4715.4
Өмчийн татвар	25246.9	22285.2	88.3	-2961.7
Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	25202.4	22229.7	88.2	-2972.7
Бууны албан татвар	44.5	55.5	124.7	11.0
Дотоодын бараа, үйлчилгээний татвар	19233.6	19019.1	98.9	-214.5
Авто тээврийн ба өөрөө явагч хэрэгслийн	19233.6	19019.1	98.9	-214.5
Бусад татвар, хураамж, төлбөр	83685.5	77797.1	93.0	-5888.4
Улсын тэмдэгтийн хураамж	25907.0	24510.6	94.6	-1396.4
Газрын төлбөр	22405.0	25153.9	112.3	2748.9
Дуудлага худалдаа сонгон шалгаруулалт	22300.0	16183.5	72.6	-6116.5
Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	143.5	88.1	61.4	-55.4
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	10499.8	9859.5	93.9	-640.3
Усны төлбөр	2078.7	1800.2	86.6	-278.5
Ойгоос хэрэглээний мод, түлээ ашигласны	47.0	31.1	66.2	-15.9
Бусад татвар, хураамж	304.5	170.2	55.9	-134.3
2. Татварын бус орлогын дүн	55517.5	55878.7	100.7	361.2
Хувьцааны ногдол ашиг	444.7	710.0	159.7	265.3
Хүү, торгуулийн орлого	25190.9	25527.0	101.3	336.1
Түрээсийн орлого	1210.0	1212.4	100.2	2.4
Төсөвт байгууллагын өөрийн орлого	7235.1	8510.9	117.6	1275.8
Өмч хувьчлалын орлого	11000.0	10962.4	99.7	-37.6
Бусад нэр заагдаагүй орлого	10436.8	8956.0	85.8	-1480.8
3. Тусlamжийн орлого	269391.7	251621.0	93.4	-17770.7
Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	235240.4	231748.8	98.5	-3491.6
ОНХС*-гийн шилжүүлгийн орлого	34151.3	19872.2	58.2	-14279.1

\* - Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан

Зураг 18. Төсвийн орлого, зарлага, сая төгрөг



2014 оны эхний 11 сард орон нутгийн төсөв болон тусгай зориулалтын шилжүүлгийн төсвөөс төсөвт байгууллагуудын төлөвлөсөн үйл ажиллагааны зардлын 64.8 хувийг буюу 609.9 тэрбум төгрөгийн зардлыг санхүүжүүлжээ. Өөрөөр хэлбэл, төсөвт байгууллагууд үйл ажиллагааны нийт зардлын 35.2 хувийг буюу 331.9 тэрбум төгрөгийг төлөвлөсөн хугацаандаа зарцуулаагүй байна.

Зураг 19. Нийслэлийн төсвийн зарлага, сая төгрөг



Төсвийн нийт зарлагын 27.0 хувийг цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, 2.9 хувийг ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, 32.5 хувийг бараа, ажил үйлчилгээний зардал болон бусад зардал, 12.6 хувийг нийгмийн халамжийн үйлчилгээ, 25.0 хувийг хөрөнгө оруулалт, их засварын зардал тус тус эзэлж байна.

Хүснэгт 17. Нийслэлийн төсвийн зарлага, сая төгрөг

	Орлогын дүн	Зарлага				Орлого, зарлагын зөрүү
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү	
Багануур	9248.0	13324.5	11567.6	86.8	-1756.9	-2319.6
Багахангай	2095.2	5135.9	3985.3	77.6	-1150.6	-1890.1
Баянгол	51643.3	59320.5	50378.9	84.9	-8941.6	1264.4
Баянзүрх	61743.6	67303.3	54485.1	81.0	-12818.2	7258.5
Налайх	11021.5	15099.8	13923.9	92.2	-1175.9	-2902.4
Сонгинохайрхан	55502.2	61598.2	54343.3	88.2	-7254.8	1158.9
Сүхбаатар	55951.2	62964.4	51357.7	81.6	-11606.8	4593.5
Хан-Уул	42490.6	41457.7	36059.7	87.0	-5397.9	6430.9
Чингэлтэй	47337.9	43531.8	37686.6	86.6	-5845.2	9651.3
Нийслэлийн шууд	368032.1	572004.3	296062.6	51.8	-275941.7	71969.5
Нийт дүн	705065.6	941740.4	609850.9	64.8	-331889.6	95214.7

### Хүснэгт 18. Өглөгтэй дүүргүүд, сая төгрөг

	11-р сарын эхний үлдэгдэл	Шинээр үүссэн өглөг	Тухайн сард төлөгдсөн	11-р сарын эцсийн үлдэгдэл
Багануур	51.0	16.6	22.4	45.2
Багахангай	27.1	0.1	18.1	9.1
Баянгол	197.2	74.5	4.5	267.2
Баянзүрх	250.9	9.8	54.2	206.5
Налайх	166.1	95.6	0.5	261.2
Сонгинохайрхан	631.9	213.1	138.4	706.6
Сүхбаатар	188.2	140.5	0.0	328.7
Чингэлтэй	57.5	1.0	32.4	26.1
Хан-Уул	205.8	91.5	59.1	238.2
Нийслэлийн шууд	255.5	0.0	6.1	249.4
Нийт	2031.2	642.7	335.7	2338.2

Нийслэлийн төсөв болон тусгай зориулалтын шил-жүүлгийн төсвөөс санхүүждэг байгууллагууд сарын эхэнд 2031.2 сая төгрөгийн өглөгтэй байснаас тайлант хугацаанд шинээр 642.7 сая төгрөгийн өглөг үүсч, тухайн сард 335.7 сая төгрөгийн өглөгийг төлж барагдуулан, сарын эцэст 2338.2 тэрбум төгрөгийн өглөгтэй үлдсэн байна.

### Хүснэгт 19. Авлагатай дүүргүүд, сая.төгрөг

	11-р сарын эхний үлдэгдэл	Шинээр үүссэн авлага	Тухайн сард барагдуулсан	11-р сарын эцсийн үлдэгдэл
Багануур	13.3	0.0	6.5	6.8
Багахангай	1.5	0.0	0.0	1.5
Баянгол	64.9	0.0	6.9	58.0
Баянзүрх	13.2	0.0	0.0	13.2
Сонгинохайрхан	5.2	0.0	0.6	4.6
Сүхбаатар	21.6	0.0	0.0	21.6
Чингэлтэй	3.6	1.5	0.0	5.1
Нийслэлийн шууд	284.8	0.0	15.5	269.3
Нийт	408.1	1.5	29.5	380.1

Төсөвт байгууллагууд сарын эхэнд 408.1 сая төгрөгийн авлагатай байснаас тайлант хугацаанд шинээр 1.5 сая төгрөгийн авлага үүсч, 29.5 сая төгрөгийн авлагыг барагдуулан сарын эцэст 380.1 сая төгрөгийн авлагатай үлджээ.



### НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ

2014 оны эхний 11 сард нийслэлийн нийгмийн даатгалын салбарын үйлчилгээнд 23.1 мянган байгууллагын 621.8 мянга гаруй хүн хамрагдаж шимтгэл төлжээ.

Нийт шимтгэл төлөгчдийн 429.3 мянга буюу 69.0 хувь нь аж ахуйн нэгж байгууллагын, 107.5 мянга буюу 17.3 хувь нь төсөвт байгууллагын, 85.1 мянга буюу 13.7 хувь нь сайн дурын даатгуулагчид байна. Даатгуулагчийн тоо өмнөх оны мөн үеэс 8.9 хувиар буюу 50.9 мянган хүнээр нэмэгджээ.


Зураг 20. Даатгалын сангийн орлого, сая төгрөг



Нийслэл, дүүргийн нийгмийн даатгалын байгууллагууд нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөг 90.0 хувиар биелүүлж, нийгмийн даатгалын санд нийт 629.4 тэрбум төгрөг хуримтлуулсан байна.

Даатгалын санд хуримтлуулсан нийт шимтгэлийн орлогын 63.6 хувь нь тэтгэврийн даатгалын санд, 18.9 хувь нь эрүүл мэндийн даатгалын санд, 7.3 хувь нь тэтгэмжийн даатгалын санд, 8.5 хувь нь үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний (ҮОМШӨ) даатгалын санд, 1.7 хувь нь ажилгүйдлийн даатгалын санд тус тус төвлөрчээ.

Зураг 21. Даатгалын сангийн зарлага



насны, 10.3 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн, 3.7 хувийг тэжээгчээ алдсаны, 12.5 хувийг цэргийн тэтгэвэрт зарцуулсан байна.

Нийслэлийн нийгмийн даатгалын сангаас эхний 11 сард даатгуулагч, иргэдэд 746.4 тэрбум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, сургалтын болон эмчилгээний зардал, эмийн үнийн хөнгөлөлт олгосон байна.

Нийт зардлын 68.7 хувийг тэтгэврийн, 15.7 хувийг эрүүл мэндийн, 7.1 хувийг ҮОМШӨний, 6.5 хувийг тэтгэмжийн, 2.0 хувийг ажилгүйдлийн даатгалын сангаас олгосон зардал эзэлж байна.

Тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэр авагч иргэдийн тоо 11 дүгээр сард 135.3 мянга, олгосон тэтгэврийн хэмжээ өссөн дүнгээр 406.9 тэрбум төгрөгт хүрчээ.

Олгосон нийт тэтгэврийн 73.5 хувийг өндөр

#### ХҮН АМЫН АЖИЛ ЭРХЛЭЛТ



Хөдөлмөрийн яамны захиргааны статистик мэдээгээр дүүргийн хөдөлмөрийн хэлтэст бүртгэлтэй, ажил идэвхтэй хайж байгаа ажилгүй иргэдийн тоо нийслэл хотод 2014 оны 11 дүгээр сарын эцэст 15560 болж, өмнөх оны мөн үеэс 2.6 хувь буюу 395 хүнээр өсчээ. Нийт ажилгүйчүүдийн 8818 буюу 56.7 хувь нь эмэгтэйчүүд байна.

2014 оны 11-р сард ажилгүй 7120 иргэн шинээр бүртгүүлж, бүртгэлтэй ажилгүй байсан 895 иргэн ажилд зуучлагдан орж, 5583 иргэн бүртгэлээс хасагджээ.

Зураг 22. Дүүргийн ажилгүйчүүд, УБ хотын дунд эзлэх хувь



Насны бүлгээр авч үзвэл нийт бүртгэлтэй ажилгүйчүүдийн 29.2 хувь буюу 4542 нь 15-24 насны, 37.2 хувь буюу 5785 нь 25-34 насны, 17.8 хувь буюу 2768 нь 35-44 насны, 15.8 хувь буюу 2465 нь 45-аас дээш насны хүмүүс байна.

Бүртгэлтэй ажилгүйчүүдийн 20.2 хувь буюу 3151 нь Баянзүрх, 15.3 хувь буюу 2386 нь Баянгол, 15.2 хувь буюу 2365 нь Сонгинохайрхан, 13.7 хувь буюу 2129 нь Чингэлтэй, 12.7 хувь буюу 1975 нь Хан-Уул, 11.1 хувь буюу 1720 нь Сүхбаатар, 8.1 хувь буюу 1253 нь Налайх, 2.8 хувь буюу 440 нь Багануур, 0.9 хувь буюу 141 нь Багахангай дүүрэгт тус тус амьдарч байна.

Хүснэгт 20. Бүртгэлтэй ажилгүйчүүд, боловсролын түвшнээр /12-р сарын 1-ний байдлаар/

	Ажилгүйчүүдийн тоо			Дунд эзлэх хувь		
	2012	2013	2014	2012	2013	2014
Нийт ажилгүйчүүд	14031	15165	15560	100	100	100
Үүнээс: дээд боловсролтой	5752	5946	6235	41.0	39.2	40.1
Тусгай дунд боловсролтой	974	1466	1031	6.9	9.7	6.6
Мэргэжлийн анхан шатны боловсролтой	1250	720	798	8.9	4.7	5.1
Ерөнхий боловсролтой	5986	6978	7411	42.7	46.0	47.6
Мэргэжилгүй	69	55	85	0.5	0.4	0.

2014 оны эхний 11 сард 42958 хүн дүүргийн хөдөлмөрийн хэлтэст ажилд орохоор шинээр бүртгүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 19.7 хувь буюу 7063 хүнээр өсчээ.

2014 оны эхний 11 сард 9223 хүн хөдөлмөрийн хэлтсээр зуучлуулан ажилд орсны 3.0 хувь нь улсын үйлдвэрийн газарт, 8.1 хувь нь төрийн төсөвт байгууллагад, 88.9 хувь нь компани, нөхөрлөл, хоршоо болон бусад газарт ажилд оржээ.



### ХОТЫН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

Нийслэл хотын нутаг дэвсгэрт 2014 оны эхний 11 сард нийт 403 гамшиг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 26.3 хувиар буурчээ.

Нийт гамшигт гахайн мялzan өвчний 2 тохиолдол, гахайн үржил-амьсгалын замын хам шинж өвчний 2 тохиолдол бүртгэгдэж, 1323 гахайг устгасан байна. Мөн үхрийн хорт салст хатуурал өвчний 1 тохиолдол, ус, цаг агаарын гаралтай аюулт үзэгдлийн 6 тохиолдол бүртгэгджээ. Харин хүний үйл ажиллагаатай холбоотой тэсэрч дэлбэрэх бодисын осол 1, сум галт хэрэгслийн осол 9, химийн бодисын осол 22, бичил уурхай, нурангыны осол 5, усны осол 9, барилгын осол 1, үйлдвэрийн осол 2, бусад осол 343 гарчээ.

Гамшгийн улмаас 49 хүн амь насаа алдсан байна. Гамшгаас 471 хүнийг аварч, гамшгийн уршгийг арилгах ажилд нийт 47.0 сая төгрөг зарцуулсан байна.

### Хүснэгт 21. Хүний үйл ажиллагаатай холбоотой осол, төрлөөр

Ослын төрөл	2013 он	2014 он	2014 % 2013
Бүгд	525	392	74.7
Тэсэрч дэлбэрэх бодисын	4	1	25.0
Сум галт хэрэгслийн	7	9	128.6
Химиин бодисын	49	22	44.9
Бичил уурхай, нурангины	7	5	71.4
Усны осол	8	9	112.5
Барилгын осол	4	1	25.0
Үйлдвэрийн осол	3	2	66.7
Бусад	443	343	77.4

Нийслэл хотод 2014 оны эхний 11 сард ой хээрийн 4, ахуйн 2784 гол түймэр гарчээ. Ахуйн гол түймрийн 31 нь Багануур, 6 нь Багахангай, 408 нь Баянгол, 669 нь Баянзүрх, 114 нь Налайх, 436 нь Сүхбаатар, 262 нь Хан-Уул, 315 нь Чингэлтэй, 543 нь Сонгинохайрхан дүүрэгт тус тус гарсан байна.

Гал түймрийг гарсан шалтгаанаар нь ангилбал цахилгаанаас 479, санамсаргүй байдлаас 1840, санаатай үйлдлээр 10, шалтгаан тогтоогдоогүй 221, бусад шалтгаанаар 234 гол түймэр гарсан байна.

Гал түймрийн улмаас 38 хүн (үүнээс, хүүхэд 9) амь насаа алдаж, 25 хүн (үүнээс, хүүхэд 3) түлэгдэж гэмтжээ. Гал түймрийн аюулаас 441 хүн, 453 байшин барилга, 17.0 тэрбум төгрөгийн эд хөрөнгийг аварчээ.

Гал түймэрт иргэний хувийн өмчийн 1638, төрийн өмчийн 940, хувийн аж ахуйн нэгж, байгууллагын өмчийн 206 объект өртөж, нийт 7606.3 сая төгрөгийн хохирол учирсан байна. Гал түймэрт 1556 гэр, орон сууц, 600 барилга байгууламж, тоног төхөөрөмж, 157 машин техник, 11 малын хашаа, саравч, бусад 460 объект өртсөн байна.

Нийслэлийн Онцгой байдлын газраас 2014 оны эхний 11 сард 151 барилгын зураг төсөл, ашиглалтанд хүлээн авч буй 468 барилгад хяналт тавьж ажиллажээ. Мөн 20848 айл өрх, 11187 объектод үзлэг шалгалт хийж, 47238 голын зөрчил илрүүлж, 141 байгууллагын үйл ажиллагааг нь зогсоож, байгууллага, албан тушаалтан, иргэнд 2590 заавал биелүүлэх албан шаардлага, 2770 мэдэгдэл хүргүүлж, 54.3 сая төгрөгийн торгууль ногдуулсан байна.

### Зураг 23. Гал түймэр, байршилаар



### Зураг 24. Гал түймэр, шалтгаанаар





## ГЭМТ ХЭРГИЙН БАЙДАЛ

2014 оны эхний 11 сард 15514 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 10.6 хувь буюу 1490 хэргээр өсчээ.

Гэмт хэргийн илрүүлэлт 55.9 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 0.4 пунктээр дээгүүр байна.

Зураг . Бүртгэгдсэн гэмт хэрэг, сараар



Гэмт хэргийн улмаас 5759 хүн гэмтэж осолдсоноос 7.2 хувь буюу 412 хүн нас барж, төр ард иргэдэд 75.4 тэрбум төгрөгийн хохирол учруулсны 27.0 хувь буюу 20.4 тэрбум төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлжээ.

Бүртгэгдсэн гэмт хэргийн 30.1 хувийг хулгайн, 28.3 хувийг хүний эрх, эрх чөлөөний эсрэг, 8.8 хувийг залилан, 7.8 хувийг танхайн, 6.2 хувийг тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг хэрэг тус тус эзэлж байна.

Хүснэгт 22. Нийт бүртгэсэн гэмт хэрэг, төрлөөр, эхний 11 сард

	Гэмт хэргийн тоо		Өсөлт, бууралт	
	2013 он	2014 он	Тоо	Хувь
Хүний амь	91	103	12	13.2
Хучин	166	136	- 30	- 18.1
Дээрэм	480	548	68	14.2
Хулгай	4184	4665	481	11.5
Булаалт	174	175	1	0.6
Залилан	914	1360	446	48.8
Хүний эрх, эрх чөлөөний эсрэг	3971	4389	418	10.5
Хөдөлгөөний аюулгүй байдал ashiглалтын журам зөрчих	1104	966	- 138	- 12.5
Бусдыг амиа хорлоход хүргэх	213	183	- 30	- 14.1
Ашиглах	175	158	- 17	- 9.7
Танхайрах	1310	1216	- 94	- 7.2
Бусад	1242	1615	373	30.0
<b>БҮГД</b>	<b>14024</b>	<b>15514</b>	<b>1490</b>	<b>10.6</b>

2014 оны эхний 11 сард 59617 хүн эрүүлжигдсэн нь өмнөх оны мөн үеэс 4.0 хувь буюу 2281 хүнээр өссөн байна.

Хүснэгт 23. Нийт бүртгэсэн гэмт хэрэг, дүүргээр, эхний 11 сард

дүүрэг	Нийт бүртгэсэн гэмт хэрэг		Гэмт хэргийн өсөлт, бууралт	
	2013 он	2014 он	Тоо	Хувь
Багануур	262	221	- 41	- 15.6
Багахангай	31	21	- 10	- 32.3
Баянгол	2271	2470	199	8.8
Баянзүрх	3348	3870	522	15.6
Налайх	285	312	27	9.5
Сонгинохайрхан	2518	2793	275	10.9
Сүхбаатар	2224	2288	64	2.9
Чингэлтэй	1957	2189	232	11.9
Хан-Уул	1128	1350	222	19.7
ДҮН	14024	15514	1490	10.6

Хүснэгт 24. Гэмт хэрэг бүртгэгдэх үед сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй хэргийн тоо, дүүргээр, 2014 оны эхний 11 сард

дүүрэг	Сэжигтэн тодорхойгүй хэргийн тоо	Үүнээс сэжигтнийг илрүүлж ял сонгосон	Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь	
			Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь	
Багануур	35	24	68.6	
Багахангай	5	4	80.0	
Баянгол	998	645	64.6	
Баянзүрх	2418	1196	49.5	
Налайх	81	60	74.1	
Сонгинохайрхан	1616	939	58.1	
Сүхбаатар	1090	599	55.0	
Чингэлтэй	1277	716	56.1	
Хан-Уул	624	367	58.8	
ДҮН	8144	4550	55.9	

Хүснэгт 25. Бүртгэсэн хулгайн гэмт хэрэг, дүүргээр, эхний 11 сард

дүүрэг	Нийт хулгайн гэмт хэргийн тоо		Үүнээс: хувийн өмчийн хулгайн гэмт хэргийн тоо	
	2013 он	2014 он	2013 он	2014 он
Багануур	57	33	40	28
Багахангай	4	4	4	2
Баянгол	562	624	457	498
Баянзүрх	1139	1229	1031	1050
Налайх	47	63	38	47
Сонгинохайрхан	893	960	822	854
Сүхбаатар	634	736	500	550
Чингэлтэй	516	649	450	580
Хан-Уул	332	367	301	321
ДҮН	4184	4665	3643	3930

2014 оны эхний 11 сард хүнд хэрэг 1119, хүндэвтэр хэрэг 6719, хөнгөн хэрэг 7338, онц хүнд хэрэг 338 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 2.1-38.5 хувиар өсчээ.

Зураг 26. Гэмт хэргийн тоо, ангиллаар



Гэмт хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагчийн тоо 12092 болж, 2013 оны мөн үеэс 8.9 хувь буюу 990 хүнээр өссөн байна.

Нийт хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагчийн 14.0 хувь буюу 1689 нь гэмт хэргийг бүлэглэн үйлдсэн, 21.1 хувь буюу 2548 нь согтуугаар үйлдсэн, 4.4 хувь буюу 534 нь урьд ямар нэг ял шийтгэл хүлээж байсан хүмүүс үйлджээ. Сэжигтэн, яллагдагчийн 4.7 хувь буюу 570 нь хүүхэд, 18.0 хувь буюу 2176 нь эмэгтэйчүүд байна.



### ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

2014 оны эхний 11 сард 38291 хүүхэд мэндэлсэн нь өмнөх оны мөн үеэс 1577 хүүхдээр олон байна. Нийт төрсөн хүүхдийн 14.2 хувь буюу 5453 нь бусад аймгийн харьят эхчүүдээс төрсөн байна.

Нялхсын эндэгдлийн 29.0 хувь буюу 160 нь бусад аймгийн харьят байна. Өмнөх оны мөн үеэс нялхсын эндэгдэл 1.4 промилээр өсчээ.

Хүснэгт 26. Төрсөн хүүхэд, эх, хүүхдийн эндэгдэл

	2012 он	2013 он	2014 он	2014 2013 %
Амаржсан эхийн тоо	33671	36465	37963	104.1
Амьд төрсөн хүүхэд	33853	36714	38291	104.3
Эхийн эндэгдэл	13	19	15	78.9
Нэг хүртэл насандаа эндсэн хүүхэд	445	477	551	115.5
Амьд төрсөн 1000 хүүхэд тутмаас 1 хүртэл насанд эндсэн хүүхэд	13.14	12.99	14.39	110.8

Нялхсын эндэгдлийн 26.7 хувь буюу 103 нь Сонгинохайрхан, 22.6 хувь буюу 87 нь Баянзүрх, 12.5 хувь буюу 48 нь Баянгол, 11.7 хувь буюу 45 нь Чингэлтэй, 10.1 хувь буюу 39 нь Хан-Уул, 9.1 хувь буюу 35 нь Сүхбаатар, 3.9 хувь буюу 15 нь Налайх, 2.9 хувь буюу 11 нь Багануур, 0.5 хувь буюу 2 нь Багахангай дүүрэгт тус тус гарсан байна.

Хүснэгт 27. Нийслэлд гарсан халдварт өвчин, эхний 11 сард

	хэмжих нэгж	2013 он	2014 он	өсөлт, бууралт	
				тоо/пункт	хувь
Халдварт өвчнөөр өвчилсөн бүх хүн, үүнээс	бодит тоо	16813	16381	- 432	- 2.6
	10000 хүнд	138.17	131.36	- 6.81	
Вируст хепатит	бодит тоо	1140	540	- 600	- 2.1 дах
	10000 хүнд	9.37	4.33	- 5.04	
Менингит	бодит тоо	15	5	- 10	- 3.0 дах
	10000 хүнд	0.12	0.04	- 0.08	
Цусан суулга	бодит тоо	1470	1820	350	23.8
	10000 хүнд	12.08	14.59	2.51	
Салхин цэцэг	бодит тоо	2280	2018	- 262	- 11.5
	10000 хүнд	18.74	16.18	- 2.56	
Гахай хавдар	бодит тоо	1453	186	- 1267	- 7.8 дах
	10000 хүнд	11.94	1.49	- 10.45	
Сальмонеллэз	бодит тоо	40	71	31	1.8 дах
	10000 хүнд	0.33	0.57	0.24	
Улаан эсэргэнэ	бодит тоо	197	255	58	29.4
	10000 хүнд	1.62	2.04	0.42	
Хоолны хордлого	бодит тоо	114	235	121	2.1 дах
	10000 хүнд	0.94	1.88	0.94	
Ёлом	бодит тоо	99	90	- 9	- 9.1
	10000 хүнд	0.81	0.72	- 0.09	
Бруцеллэз	бодит тоо	12	16	4	33.3
	10000 хүнд	0.10	0.13	0.03	
Нярайн халдварт	бодит тоо	1	3	2	3.0 дах
	10000 хүнд	0.01	0.02	0.01	
Гар хөл амны өвчин	бодит тоо	1160	1575	415	1.4 дах
	10000 хүнд	9.53	12.63	3.1	
Тэмбүү	бодит тоо	2952	3369	417	14.1
	10000 хүнд	24.26	27.02	2.76	
Заг хүйтэн	бодит тоо	1588	1496	- 92	- 5.8
	10000 хүнд	13.05	12.00	- 1.05	
Трихомониаз	бодит тоо	1711	1610	- 101	- 5.9
	10000 хүнд	14.06	12.91	- 1.15	
Шинээр илэрсэн сүрьеэ	бодит тоо	2195	2370	175	8.0
	10000 хүнд	18.04	19.01	0.97	
ДОХ	бодит тоо	22	31	9	40.9
	10000 хүнд	0.18	0.25	0.07	

Нийслэлд 2014 оны эхний 11 сард 16381 хүн халдварт өвчнөөр өвчилсөн нь өмнөх оны мөн үеэс 2.6 хувь буюу 432 хүнээр, 10000 хүн тутмаас халдварт өвчнөөр өвчилсөн хүний тоо 6.81 продицмилээр тус тус буурчээ.

Зураг 27. Халдварт өвчнөөр өвчлөгсөд, сараар



Халдварт өвчнөөр өвчлөгсийн 20.6 хувийг тэмбүү, 14.5 хувийг шинээр илэрсэн сурьеэ, 12.3 хувийг салхинцэцэг, 11.1 хувийг цусан суулга, 9.8 хувийг трихомониаз, 9.6 хувийг гар хөл амны өвчин, 9.1 хувийг заг хүйтэн, 3.3 хувийг вируст хепатит өвчнөөр өвчлөгсөд тус тус эзэлж байна.



### ХОТЫН НИЙТИЙН АЖ АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Нийслэлийн хүн амд 2014 оны эхний 11 сарын байдлаар 29.9 сая м<sup>3</sup>, аж ахуйн нэгж, байгууллагад 11.6 сая м<sup>3</sup> цэвэр усыг борлуулжээ. Борлуулсан усны нийт хэмжээ өнгөрсөн оны мөн үеэс 1.6 хувиар нэмэгдсэн байна.

Хүснэгт 28. Ус суваг ашиглалтын үйлчилгээ


Үзүүлэлт	Хэмжих нэгж	2013 он XI сар	2014 он XI сар	2014 / 2013 %
Шахсан ус	мян.м <sup>3</sup>	50438.4	49059.5	97.3
Борлуулсан ус	мян.м <sup>3</sup>	40824.1	41492.3	101.6
Хүн амд	мян.м <sup>3</sup>	29895.9	29853.8	99.9
ААНБ-д	мян.м <sup>3</sup>	10928.2	11638.5	106.5
Татан зайлдуулсан бохир	мян.м <sup>3</sup>	39977.3	40427.1	101.1
Хүн амаас	мян.м <sup>3</sup>	27848.8	27677.0	99.4
ААНБ-аас	мян.м <sup>3</sup>	12128.5	12750.1	105.1
Ус борлуулалтын орлого	сая төг	14657.2	18495.9	126.2
Хүн амаас	сая төг	8463.4	10231.1	120.9
ААНБ-аас	сая төг	6193.8	8264.8	133.4
Сувагжуулалтын орлого	сая төг	8150.0	10598.3	130.0
Хүн амаас	сая төг	4100.0	4757.8	116.0
ААНБ-аас	сая төг	4050.0	5840.5	144.2

Нийт борлуулсан усны 70.4 хувийг хүн амд борлуулсан ус, 29.6 хувийг аж ахуйн нэгж, байгууллагад борлуулсан ус эзэлж байна.

Хүн амд түгээсэн цэвэр усны 95.9 хувь буюу 28.6 сая м<sup>3</sup>-ыг нь төвлөрсөн шугамаар, 1.2 сая м<sup>3</sup> усыг “ус түгээх байр”-аар, 10.5 мянган м<sup>3</sup> усыг тээврээр түгээсэн байна.

Цэвэрлэх байгууламжаар 53.9 сая м<sup>3</sup> бохирыг цэвэрлэж, аж ахуйн нэгж, байгууллага, өрхийн 40.4 сая м<sup>3</sup> бохир шингэнийг татан зайлдуулсан байна.

Зураг 28. Борлуулсан ус, сараар, мян.м<sup>3</sup>



Зураг 29. Татан зайлдуулсан бохир, сараар, мян.м<sup>3</sup>



### АМЬДАРЧ БҮЙ ОРЧИН

Нийслэлийн агаарын дундаж температур 2014 оны 11 сард дунджаар  $-8.2^{\circ}\text{C}$  байв. Энэ нь өнгөрсөн оны мөн үеэс  $-0.2^{\circ}\text{C}$ -аар хүйтэн, олон жилийн дундажтай харьцуулахад  $2.8^{\circ}\text{C}$ -аар дулаан байлаа.

Энэ сард үнэмлэхүй их температур  $9.2^{\circ}\text{C}$ , үнэмлэхүй бага температур  $-23.8^{\circ}\text{C}$ , хур тунадасны нийлбэр 0.9 мм, салхины үнэмлэхүй их хурд 17 м/секунд хүрч, шороон болон цасан шуургатай 1 тохиолдлыг бүртгэжээ.


Агаар дахь бохирдуулагч бодисын агууламжийг нийслэл хотын нутаг дэвсгэрт 8 харуул цэгт хэмжихэд азотын давхар ислийн хоногийн дундаж агууламж 2014 оны 11 дүгээр сард Улаанбаатар хотын Баруун дөрвөн замын орчимд 29 удаа, 13-р хороолол орчимд 27 удаа, 32-ын тойрог орчимд 25 удаа, 1-р хороолол, Офицеруудын ордон болон Ургах наран хороолол орчимд тус бүр 6 удаа, хүхэрлэг хийн хоногийн дундаж агууламж 13-р хороолол болон 32-ын тойрог орчимд тус бүр 23 удаа, Мишээл экспо төвийн орчимд 16 удаа, Баруун дөрвөн замын орчимд 10 удаа, Хархорин захын орчимд 8 удаа, Офицеруудын ордон орчимд 7 удаа, 1-р хороолол орчимд 5 удаа, Ургах наран хороолол орчимд 4 удаа тус тус давжээ.

### Хүснэгт 29. Агаарын бохирдолт, мг/м<sup>3</sup>


Бодисын нэр		Стандарт хэмжээ	Хийсэн ажиглалтын тоо	Хамгийн их хэмжээ	Стандарт хэмжээнээс давсан тохиолдол /тоо/	Агаарт байсан дундаж хэмжээ
Хүхэрлэг хий	SO <sub>2</sub>	0.020	167	0.058	96	0.024
АЗОТЫН ДАВХАР ИСЭЛ	NO <sub>2</sub>	0.040	148	0.135	99	0.052
Тоосжилт	PM <sub>10</sub>	0.100	137	0.875	122	0.205
	PM <sub>2.5</sub>	0.050	59	0.240	45	0.090
Нүүрстөрөгчийн дутуу исэл	CO	10.0	390	4.738	-	1.225
Озон	O <sub>3</sub>	0.100	280	0.064	-	0.014

Мэдээллийн эх үүсвэр: Ус, цаг уур орчны хүрээлэн

### Зураг 2. Хүхэрлэг хийн агууламж, мг/м<sup>3</sup>




### Зураг 3. Азотын давхар ислийн агууламж, мг/м<sup>3</sup>




10 микронос бага хэмжээтэй тоосны агууламж 32-ын тойрог орчимд 30 удаа, Баруун дөрвөн зам болон 13-р хороолол орчимд тус бүр 29 удаа, Хархорин захын орчимд 20 удаа, Ургах наран хороолол орчимд 11 удаа, Мишээл экспо төвийн орчимд 3 удаа, 2.5 микронос бага хэмжээтэй тоосны агууламж Баруун дөрвөн замын орчимд 29 удаа, 13-р хороолол орчимд 16 удаа агаарын чанарын стандарт дахь хүлцэх хэм хэмжээнээс давсан байна.

Зураг 4. Тоосны /PM<sub>10</sub>/ агууламж, мг/м<sup>3</sup>



Зураг 5. Нүүрстөрөгчийн дутуу исэл, мг/м<sup>3</sup>



Хүснэгт 30. Нийслэлийн гадаргын усны найрлага, мг/м<sup>3</sup>, 11-р сард

	Стандарт хэмжээ	“Туул-Зайсан” харуул цэг		“Туул-Сонгино доод” харуул цэг	
		Хэмжээ	Бодисын хэтрэлт	Хэмжээ	Бодисын хэтрэлт
Хүчилтөрөгч (O <sub>2</sub> )	≥6	5.50	хэвийн	0.3	онцгой их бохирдолтой
Биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч (BXX <sub>5</sub> )	≤ 3	0.6		77.0	25.7 дахин
Нитридийн нэгдэл (NO <sub>2</sub> )	≤ 0.02	0.002		-	хэмжилт хийгдээгүй
Амоны азот (NH <sub>4</sub> )	≤0.5	0.05		20.20	40.4 дахин
Эрдэс фосфор (P)	≤0.1	0.028		1.372	13.7 дахин

Мэдээллийн эх үүсвэр : Байгаль орчны хэмжил зүйн төв лаборатори  
 Туул голын усны найрлага Туул-Зайсан харуул цэгийн орчимд бохирдуулагч бодисын хэмжээ хэвийн, Туул-Сонгино доод харуул цэгийн орчимд хүчилтөрөгчийн хэмжээ горим алдагдаж онцгой их бохирдолтой, амоны азот 40.4 дахин, биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч 25.7 дахин, эрдэс фосфор 13.7 дахин хүлцэх хэм хэмжээнээс хэтэрч Туул голын ус маш бохирдолтой хэвээр байна.

Хүснэгт 31. Агаар дахь бохирдуулагч бодисын хоногийн дундаж агууламж, мг/м<sup>3</sup>, 11-р сард

Агаарын бохирдлын үзүүлэлт		Мишээл Экспо төв	Баруун дервөн зам	1-р хороолол	13-р Хороо -лол	32-ын тойрог	Офицер-уудын Ордон	Хархорин зах	Ургах наран хороолол
Хүхэрлэг хий SO <sub>2</sub>	Дундаж	0.023	0.027	0.021	0.031	0.028	0.026	0.017	0.018
	Хамгийн их	0.054	0.051	0.058	0.053	0.049	0.052	0.031	0.036
	XXX*-с давсан хувь	59.3	62.5	38.5	76.7	76.7	63.6	29.6	30.8
	Хэмжилтийн тоо	27	16	13	30	30	11	27	13
Азотын давхар Исэл NO <sub>2</sub>	Дундаж	0	0.095	0.035	0.058	0.049	0.035	0	0.038
	Хамгийн их	0	0.135	0.094	0.075	0.065	0.098	0	0.049
	XXX*-с давсан хувь	0	100.0	27.3	90	83.3	25.0	0	46.2
	Хэмжилтийн тоо	0	29	22	30	30	24	0	13
Нүүрс-төрөгчийн дутуу исэл, CO**	Дундаж	0	2.059	0	0.918	1.586	0	1.066	0.497
	Хамгийн их	0	4.738	0	3.563	4.563	0	4.300	1.163
	XXX*-с давсан хувь	0	0	0	0	0	0	0	0
	Хэмжилтийн тоо	0	88	0	84	90	0	87	41
Тоос PM10	Дундаж	0.074	0.282	0	0.2	0.339	0	0.177	0.157
	Хамгийн их	0.125	0.421	0	0.317	0.875	0	0.27	0.481
	XXX*-с давсан хувь	20	100	0	96.7	100.0	0	95.2	91.7
	Хэмжилтийн тоо	15	29	0	30	30	0	21	12
Тоос PM2.5	Дундаж	0	0.120	0	0.059	0	0	0	0
	Хамгийн их	0	0.240	0	0.094	0	0	0	0
	XXX*-с давсан хувь	0	100.0	0	53.3	0	0	0	0
	Хэмжилтийн тоо	0	29	0	30	0	0	0	0
Озон O3**	Дундаж	0.008	0	0	0.01	0.008	0	0	0.029
	Хамгийн их	0.016	0	0	0.032	0.028	0	0	0.064
	XXX*-с давсан хувь	0	0	0	0	0	0	0	0
	Хэмжилтийн тоо	89	0	0	60	90	0	0	41

\*- Хүлцэх хэм хэмжээ, \*\*- CO, O3 -ийн хэмжилтийг 8 цагийн дунджаар тооцсон.

## БАЙГАЛЬ ОРЧНЫ ЗӨРЧИЛ

Нийслэлд 2014 оны эхний 11 сард байгаль орчныг хамгаалах хууль, тогтоомжийг зөрчсөн 243 зөрчлийг илрүүлжээ.

Зөрчлийн тоо өмнөх оны мөн үеэс 9.7 хувиар буурч, нийт зөрчлийн 28.8 хувийг газрын хэвлий, ашигт малтмал, уул уурхайн зөрчил, 18.5 хувийг газрын зөрчил, 12.3 хувийг агаар, химийн хорт бодисын зөрчил, 8.2 геодези зураг зүй, кадастрын зөрчил, 7.8 хувийг ойн зөрчил, 24.4 хувийг бусад зөрчлүүд тус тус эзэлж байна. Илрүүлсэн нийт зөрчилд 93.5 сая төгрөгийн торгууль ногдуулж, ойн зөрчлөөс 2.8 сая төгрөгийн эд зүйлс хураан авчээ.

Хүснэгт 32. Байгаль орчны зөрчил, төрлөөр

Илрүүлсэн зөрчил, төрлөөр	2013 оны эхний 11 сар			2014 оны эхний 11 сар		
	Үзлэг шалгалт	Илрүүлсэн зөрчил	Торгууль /мян.төг/	Үзлэг шалгалт	Илрүүлсэн зөрчил	Торгууль /мян.төг/
Ой	67	108	20076.0	37	19	7728.0
Ан, амьтан	11	6	805.2	6	4	-
Газрын	64	38	25716.8	90	45	31510.0
Ус	16	8	10404.0	4	2	3772.0
Ургамал, хөрсний бохирдол	69	62	1985.6	15	16	2554.0
Агаар, химийн хорт бодисын	17	15	467.8	56	30	2516.0
Газрын хэвлэй, ашигт малтмал, уул уурхай	19	6	4123.0	156	70	24102.0
Геодези зураг зүй, кадастр	22	15	1400.0	31	20	2518.0
Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ	-	-	-	2	3	14400.0
Бусад	17	11	5169.6	62	34	4370.0
Бүгд	302	269	70148.0	459	243	93470.0



<http://ubstat.mn>



Статистикийн ном, эмхэтгэл,  
танилцуулга, сэтгүүлийг энэхүү  
апп-ыг ашиглан унших боломжтой



[www.1212.mn](http://www.1212.mn) -ээс статистик мэдээллийг  
интерактив байдааар аваарай